



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/09

Хашаат

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргааны нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.4, Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн аймгийн Засаг даргын А/742 тоот захирамж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2015 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 22 тоот тогтоолын хавсралт "Мал хамгаалах сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.5, 3 дугаар зүйлийн 3.1.2, Сумын Засаг даргын зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/742 тоот захирамжаар тус суманд хуваарилсан 800 шуудай хивгийг Эрдэнэдалай сумаас татах ажлыг зохион байгуулсугай.

2. 800 шуудай хивгэн тэжээлийн үнэ 8,300,000 (найман сая гурван зуун мянга) туслах ажилчдын ажлын хөлс 800,000 (найман зуун мянга), тээврийн хөлс 2,465,000 (хоёр сая дөрвөн зуун жаран таван мянга) төгрөг, бусад зардал 200,000 (хоёр зуун мянга) төгрөг, ажлын хэсгийн томилолтын зардал 128000 (нэг зуун хорин найман мянга) төгрөг нийт 11,893,000 (арван нэгэн сая, найман зуун ерөн гурван мянга) төгрөгийг мал хамгаалах сангаас зарцуулахыг Тусгай сангууд хариуцсан нягтлан бодогч (Г.Ганбаатар)-д даалгасугай.

3. Улсын нөөцөөс хөнгөлөлттэй үнээр олгож буй 800 шуудай хивгийн чанар байдалд хяналт тавьж, бүрэн хүлээж авахыг ажлын хэсгийн ахлагч Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Б.Наранцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА ЦОДБАЯР

